



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А/363

Булган сум

### Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дэх хэсэг, Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоол, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV хуралдааны аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай” IV/25 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд “Брэндбүүк” буюу брэндийн гарын авлага боловсруулах ажлыг гүйцэтгэх иргэн Б.Ням-Эрдэнэтэй шууд гэрээ байгуулах эрхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албаны дарга (Э.Эрболд)-д олгосугай.

2.Худалдан авах үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албаны дарга (Э.Эрболд)-д үүрэг болгосугай.

3.Гэрээнд заасан ажил үйлчилгээг стандарт, журам, зааврын дагуу хүлээлгэн өгөхийг (Б.Ням-Эрдэнэ)-д даалгасугай.

4.Гүйцэтгэх ажлын жагсаалтыг хавсралтаар баталж, шаардагдах санхүүжилт болох 5,800,000 (таван сая найман зуун мянга) төгрөгийг Аймгийн Засаг даргын тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрсөн Булган аймаг, “Эрдэнэт үйлдвэр” Төрийн өмчит үйлдвэрийн газрын 2026 онд хамтран ажиллах төлөвлөгөөний зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2026 оны  
105 дугаар сарын 10-ны/ний өдрийн  
А/363 дугаар захирамжийн хавсралт



## ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ЖАГСААЛТ

### 1. ЛОГО

- 1.1. Логоны байгуулалт
- 1.2. Логоны өнгөний код, уриа үг
- 1.3. Өнгөт дэвсгэр дээрх логоны хэрэглээ
- 1.4. Хар цагаан дэвсгэр дээрх логоны хэрэглээ
- 1.5. Фото зураг дээрх логоны хэрэглээ
- 1.6. Текстэн дунд байрлах логоны хэрэглээ
- 1.7. Үсгийн фонт

### 2. АЛБАН ХЭРЭГЛЭЭ

- 2.1. Дугтуй
- 2.2. Туг, дарцгийн загвар

### 3. АЖИЛТНУУДЫН ХЭРЭГЦЭЭ

- 3.1. Мандат

### 4. БАЙГУУЛЛАГЫН ХЭРЭГЦЭЭ

- 4.1. Илтгэлийн дэвсгэр
- 4.2. Хурал зөвлөгөөний илтгэл танилцуулгын загвар
- 4.3. Уриалга, мэндчилгээ
- 4.4. Бусад зүйлс

### 5. СУРТАЛЧИЛГАА

- 5.1. Тараах материал
- 5.2. Постер
- 5.3. Тайлан танилцуулга

--o00o--